



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 10 сарын 04 өдөр

Дугаар АА633

Улаанбаатар хот

Ажлын баг, хяналтын
инженер томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8.2, 11.1 дэх хэсэг, ИНД-172 "Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт" дүрмийн 172.157, ИНД-171 "Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллага - үйл ажиллагаа ба гэрчилгээжүүлэлт" дүрмийн 171.79.(а)-6.3, Холбоо, навигаци, ажиглалтын албаны "Үйл ажиллагааны заавар"-ын 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар болон Красноярск бүсийн нислэгийн хөдөлгөөн удирдах төвүүд хоорондын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний өгөгдөл солилцох /OLDI/ ажлын хүрээнд Aircon 2100 автоматжуулалтын системийн холболт тогтоох, өгөгдөл солилцож турших ажлыг 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн UTC 00:00 цагаас 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн UTC 16:00 цаг хүртэл хийж гүйцэтгэх ажлын баг, хяналтын инженерийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын багийн ахлагч:	Б.Мөнхбаяр	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Ажиглалт, автоматжуулалтын хэсгийн Техник ашиглалтын тасгийн ахлах инженер
Гишүүд:	Г.Мөнхбат	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Ажиглалт, автоматжуулалтын хэсгийн Техник ашиглалтын тасгийн инженер
	Д.Оюунболд	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн ахлах инженер
	Б.Цэнд-Аюуш	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Мэдээллийн технологийн тасгийн ахлагч инженер

Г.Нандин-Эрдэнэ	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Мэдээллийн технологийн тасгийн ахлах инженер
Ц.Батсайхан	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын хэсгийн дарга
Ц.Амарсанаа	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын хэсгийн менежер
Б.Энхмөнх	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын хэсгийн ерөнхий нислэгийн удирдагч
Хяналтын инженер:	Д.Доржмягмар
	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Ажиглалт, автоматжуулалтын хэсгийн Техник ашиглалтын тасгийн ахлагч инженер

2. Дээрх туршилтын ажлыг хийхдээ ашиглалт, техникийн бэлэн байдлыг хангаж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрсдэлгүйгээр зохион байгуулан ажиллахыг Холбоо, навигаци, ажиглалтын алба /Д.Баяртогтох/, нислэгийн хөдөлгөөний удирдлагад сөргөөр нөлөөлөхгүйгээр аюулгүй ажиллагааг хангаж, зохих хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба /П.Мөнхжаргал/, нислэгийн үйл ажиллагаатай холбоотой зохих байгууллагуудад зарлан мэдээлэх ажлыг зохион байгуулахыг Нислэгийн мэдээллийн үйлчилгээний алба /П.Ариунгэрэл/-нд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газар /Ё.Эрдэнэбат/-т даалгасугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН